

Төгс туулсан багш бол гэрт орох түүлхүүрийг барьж байгаа хүн юм. Тэр чамайг төгс туулсан багш болгож чадна... Чамд тусалж та өөрийгөө бас төгс туулсан багш мөн гэдгийг ойлгуулан таниулна. Энэ нь төгс туулсан багшийн цорын ганц зорилт юм.

—Suma Ching Hai—

Манай номын цогцос шашин суртахуун бус. Би хүмүүсийг өөрчлөн католик шашин буюу бурхны шашин эсхүүл ондоо шашин шүтлэгийг шүтүүлье гэсэн биш. Би зөвхөн та нарт нэгэн арга барилыг олгон өгч, өөрийгөө ойлгон, хаанаас ирснээ мэдэж, нөгчсөний дараахь байдлыг мэдүүлэх гэсэн юм.

—Suma Ching Hai—

Бид хаан хурмастаас хөндий зайдуу

болсон нь ажил дэндүү арвинаас болжээ. Ямар нэгэн хүн тантай ярилцаж байхад утас дахин дахин дуугараад байдаг. Та бас хоолоо хийх хэрэгтэй. Энэ үед та өөр хүнтэй харилцаж чадахгүй болдог. Хаан хурмастад бас ийм байдал тулгарч мэднэ. Тэр өдөр бүр утасдаж байтал, бид утас авах завгүй.

—Suma Ching Hai—

## Suma Ching Hai—н ТОВЧ НАМТАР

Чинхай багш Вьетнам улсад мэндэлжээ. Эцэг нь ард түмэндээ маш их итгэл хүндтэй хятад анагаах ухааны эмч бөгөөд дэлхийн утга зохиолыг бахдан уншиж, философид онц дур сонирхолтой хүн байжээ. Чинхай багш багадаа Хятадын эртний их зохиолч Лууз, Жуанз нарын зохиолуудыг сонирхон уншиж байсан. Бага сургуульд ороогүйгээр өрнө дахины философийн номуудыг хэдийний уншчихсан байжээ.

Чинхай багш ерийн хүүхдүүдтэй адилгүй байсан. Бусад хүүхдүүд хичээлээ давтах буюу тоглож байхад Чинхай философийн номуудыг уншиж байдаг. Эдгээр ном зохиолуудыг ойлгож байна уу гэж эцэг нь асуусанд: " Хэрэв ойлгохгүй бол унших сонирхолгүй

болчихно " гэж хариулжээ. Түүний сурлагын хэр бүтэмж нь сургуульдаа онц сайн байдаг тул эцэг нь түүний сонирхлыг дэмжиж байв.

Түүний эцэг эх нь хэдийгээр католик шашаинтан байсан боловч бурхны шашныг чөлөөтэй байлгахыг зорьдог байжээ. Түүний эмээ бурхан шашныг шүтдэг байсан тул Чинхай багш түүнийг даган ном уншиж мөргөл хийх дуртай байсан. Чинхай багш ийм орчинд хүмүүжигдэн тул шашин суртахуунуудыг хамтаар байлгах үзэл санаатай болсон байна. Өглөөдөө католикийн шашны сүмд мөргөл гүйцэтгэж, Үдийн хойно хуушангийн сүмд очиж, орой бас дахин бомбын дуганд ном сонсож байсан. Ийм учраас түүнд орчлон ертөнцийн хүний амьдралын тухай сэжигтэй асуудлууд

бодогдох болжээ. Жишээлбэл " Хүн хаанаас ирсэн? Нас нөгчсөний дараа хаа очих? Хүмүүсийн хувь заяа хоорондоо яагаад ийм их зөрөөтэй байдаг?" гэх мэт.

Вьетнамын дайны Үед түүний орон нутагт эмч сувилагч их дутадаж байсан тул хичээлийн зав чөлөөгөөрөө эмнэлэгт очин тусалж байлаа. Өвчтөний яр шархыг угаан цэвэрлэж, шээсний савыг нь арчиж зүлгэх зэргээр өөрийн хэрчадлаараа тэдний зовуурийг хөнгөлж байв. Олон улсын найз нар түүнийг " эдүүгээх бурхан", " юүмэр шогтой богд" гэж нэрийдэж байжээ. Учир нь багш угаасаа юүмэр шогтой, нигүүлсэнгүй сайхан сэтгэлтэй хүн юм.

Амьтанд бас нигүүлсэнгүй сэтгэлтэй юм. Шархтай амьтныг олж үзвэл гэртээ авчирч эмнээд тавьж явуулдаг. Ялангуяа алагдсан амьтныг харвал нүднээс нь

нуимс асгарч, ертөнцийн зовлон зүдүүрийнг яаж арилгах тухай аргыг сүвэгчилдэг. Нэг насаараа бацаг барьсан болохоор улаан идээний зүйл буюу мал алахыг харвал даруй буруулан зайлдаг.

Чинхай багшийг бага байхад нь нэг төлөг үзэгч түүнийг " Төрөлх билэг түмнээс давж, ариун дээд зан моральтай, хувь заяа ихтэй, бясалгал хийвэл сайн мөрийг олж, гэрлэвэл ургийн холбоо төгс сайхан болж, хүмүүсийг бишрүүлмээр сайхан хүргэн олно " гэж зөгнөн өгүүлжээ. Түүнийг том болсны дараа адил бус орны төлөгч нар үүнтэй эгээ адилаар зөгнөн өгүүлсэн гэнэ.

Чинхай багш гэрээсээ гарч яваад Гималайн нурууд хүрсний дараа ээж нь хамгаас алдар хүндтэй нэгэн сүмд очиж охиндоо даатгал хийжээ. Арявалын төлөгт " Багш бол түм буман хүмүүсийн

дундаас олдошгүй ховор эрхэм хүн, савловагдэнт ертөнцөд ирж, биднийг зовлонгоос гаталгагч онгоцоор гаслангийн далайгаас ангижруулна." гэж буужээ.

Германийн улаан загалмайт нийгэмлэгт хэлмэрчээр ажиллаж байхдаа, өөрийн эрүүл мэндээ үл хайхран, сайн дураасаа өглөөнөөс орой болтол олон цагаар ажиллан Тайваний дүрвэгчдэд үйлчилж байлаа. Ажлын бодитой орчноос болж, олон улсын дүрвэгчдийн зовлон зүдүүрийг Чинхай багш нэлээд гүнзгий ойлгосон юм. Мөн дайн дажин болон байгалийн гамшгаас болсон гаслан зовлонг ч үргэлж харж байсан. Эдгээр гаслан зовлонг хөнгөлөх сэн гэж бас бодсон. Гэвч ганц хүний хүчээр хүн төрөлхтний эдгээр зовлон зүдүүрийг хориглон зогсоож болохгүй юм байна гэдгийг тэр өөрөө сайн ойлгосон байна. Харин "билэг

нээгдвэл" хүн төрөлхтний гаслан зовлонг хөнгөлж болно гэж ойлгоод, билэг нээх явдлыг эхэлж оролдлоо. Европод байсан хугацаандаа чармайн бясалгаж, нэлээд олон багшийг дагаж, зүйл бүрийн номын цогцсыг бясалгаад, зөндөө арвин номыг уншин судалсан байна. Олон зүйлийн номын цогцсыг бясалгасан боловч ном сударт өгүүлэгддэг билэг нээгдэх арга болон хэт ертөнцийн хүслэнт ахуйг эрж олсонгүй. Энэ нь түүний сэтгэлийг маш их гутруулсан байна.

Чинхай багш шашин суртахуун бүхэнд адилаар хандаж, сонгодог зохиолуудыг гүнзгий судлан гүйцэд ойлгож, Есүс, Күнз, Луузын ном зохиол ба бусад шашин суртахууны философиос жишээ авч хэрэглэдэг. Иймээс бид их багш нарын өгүүлсэн сургаалууд нь цөм адил гэснийг

ойлгожээ. Шашин суртахуудын ялгаа нь хүмүүсийн зохиосон зүйл болох бөгөөд цаг үеийн зөрөөнөөс болсон гэдгийг багш үргэлж бидэнд тайлбарлан өгдөг юм.

Германд сууж байсан хугацаандаа шинжлэх ухаан, анагаах ухааны хошой докторын цол хамгаалсан эрдэмтэнтэй гэрлэж, ургийн төгс холбоог байгуулжээ. Түүний хөхөр нь ер бусын уужуу тавиу зантай, ёс журмыг сайн мэддэг хүн юм байжээ. Тэр хүн хатнаа дагаж бацаг барихаар үл барам бас хань болон жуулчилж, ариун оронд очиж богд мэргэдтэй барааддаг байна. Чинхай багш бясалгалын мөрийг хөөхийн төлөө ургийн холбоогоо цуцлах санаа оржээ. Тэгээд Чинхай багш нөхөртэйгөө сайтар зөвлөн ярилцсаны үр дүнд нөхрийнхөө зөвшөөрөл ба уучлалыг олсон байна. Энэ явдал нь Үнэндээ тэдний сэтгэлийг маш

ихээр шимшрүүлэн зовоосон юм. Гэвч энэ нь зөв сонголт гэж тэдэнд бодогдсон. Билэг нээгдэх ёсыг олохын төлөө арга бус ингэх л хэрэгтэй болсон байна.

Чинхай багш ургийн холбоогоо тасалсны дараа хүнийг энэ төрөлд нь туулан тонилгож болох төгс сайхан номын цогцсыг нэгэн сэтгэлээр эрж сураглав. Гэвч түүний багш нар ийм номын цогцсыг цөм мэдэхгүй байжээ. Хэдэн жилийн дараа Гималайн нуруунаас нэгэн төгс туулсан багшийг олжээ. Тэр багш түүнд сэтгэлийн авишиг хүртээн, олон жил эрж сураглаж байсан Арявалын номын цогцсыг уламжилж өгөв. Арявалын номын цогцсыг нэг хугацаа бясалгасны дараа билгээ гүйцэд нээгдүүлэхийн төлөө улам хичээхгүйлэн бясалгав. Үүний дараа мөн Гималайн нуруунд хаалга битүүмжлэн бас нэг

хугацаа бясалгажээ.

Чинхай багш Гималайн нуруунаас буусны дараа Тайваньд залран саатжээ. Чинхай багш догшин салхи ширүүн бороонтой шөнө нэгэн сүмийн арын бяцхан гэрт сэм завидал хийж байтал хүмүүс үүдийг нь догшив. Тэдний ирсэн зорилгыг асуусанд: " Манай залбиран хүссэн зүйлийг Арявал хариулж, энд ирэгтүн гэж зааварласан. Төгс туулсан багш минь жинхэнэ номоо уламжилж, туулан тонилгохыг хүснэ" гэж тэд хариулжээ. тэднийг буцаая гэж оролдсон боловч тэд явсангүй. Тэдний чин үнэнч сэтгэл нь багшийн сэтгэлийг хөдөлгөжээ. Тэгээд бацаг барьж бие цогцоо хэдэн сар ариутгасны дараа сэтгэлийн авишиг хүртээе гэж зөвшөөрчээ. Төрөлхийн ичимтгий зантай Чинхай шавь дагуулъя гэж ер бодсонгүй

харин хүмүүсийн ирэхээс болгоомжилж  
нуун далдалж байжээ. Энэтхэг, Герман,  
Тайвань, Америкт байхдаа ч мөн чадахын  
дотор хүмүүсээс зайлж, нэгэн бяцхан  
сүмд чимээ аниргүй суудаг байжээ.  
Тайваньд энэ удаа гурав дахь удаагаа  
хүнд мэдэгдээд, энэхүү түлхэж  
болшгүй ариун үүргээс дахин зугтан  
зайлж болохгүй гэдгийг мэджээ. Үүнээс  
эхлэн номын ёсоо сурталчлан  
дэлгэрүүлж, санаа нэгтэнтэйгээ үнэн  
ёсыг хамтаар суралцаж, чин сэтгэлийн  
угаас шавь болохыг хүсэгчдэд сэтгэлийн  
авишиг хүртээж, номын ёсыг  
уламжилдаг болжээ.

Тайваний энэхүү хүмүүсийн  
ухуулгаар Чинхай багшийн номын ёсыг  
мянга түмэн хүн мэджээ. Багш тайваньд  
удаан жил суусан тул олонхи шавь нь  
цөм Тайваньд байна. Ойрын жилүүдэд

Ази, Америк, Латин Америк, Австарли, Канад, Мексик, Европоор тойрон явж номоо сурталчилжээ. Нийгмийн олон давхаргын адил бус шашин шүтлэгтэд түүний туслалцаагаар бясалгал нь ихээр сайжирсан байна. Түүний номын ёсыг зохион байгуулалт байгуулж сурталчлан дэлгэрүүлсэнгүй ч, түүний нигүүлсэнгүй энэрэнгүй сэтгэлийг мэдэх шавь буюу найз нар харин дэлхий даяар түгж байна. Чинхай багшаас номын ёсыг сурах хүсэлтэй хүмүүст бид цаг тухайд нь дэмжлэг үзүүлэх дуртай байна.

Чинхай багш номын ёсыг тайлбарлаж, сэтгэлийн авишиг хүртээн, мянга түмэн хүнийг туслахаас гадна бас гамшиг зовлон эдэлж байгаа ядуу зүдүү гачигдалтай хүмүүсийг тусалж байна. Ойрын жүлүүдэд хүмүүлэг ёсны ажилд оролцсоноос болж үй олон хүмүүсийн

сэтгэлийг олжээ. Чинхай багшид энэ тэр гэж ялгаварлах үзэл байдаггүй тул, харанхуй балай, юмгүй ядуу, санамсаргүй аюул зовлонд дайрагдсан хүмүүсийг цөм тусалдаг. Нэг л үгээр хэлбэл, хаа зовлон байвал тэнд дэмжлэг үзүүлдэг.

Өнгөрсөн жилүүдэд Чинхай багшийн энэрэнгүй сэтгэлийн тусламжийг хүртсэн газрууд гэвэл: Бүх Америкийн орох гэргүй тэнүүлчид; Өмнөд Калифорнийн их түймэрт гамшигдсан иргэд; Америкийн дунд ба баруун хэсэг, Хятадын эх хуурайн дунд ба зүүн хэсэг, Малайзи, Вьетна, Холланд, Белги, Франц улсын усны аюулд гамшигдсан иргэд; Бразилийн ядуу хөгшид; Филиппиний Биндобе галт уул дэлбэрэхэд орон сууцаа алдагчид; Тай улсын умард дахь гамшигсан иргэд; Тайвань болон

Шингафурын ядуу айлууд; Хавайн  
Морока арлын нойтон хамуу өвчтөн;  
Герман, Уганд, Энэтхэгийн билэг  
бясалгалын бүлгэм; Хавайн бядуу  
хүүхдийн гэр бүл; Лосанжүвесийн газар  
хөдлөлтөд гамшигдсан иргэд; Америкийн  
AIDS өвчин ба өмөн өвчний эм, эмнэлэг  
судлах байгууламж зэрэг маш олон  
газрууд байна. Энэхүү ажил нь бас  
тасралтгүй үргэлжилсээр...

Үүнээс гадна, дүрвэгчдийн лагер  
дахь Вьетнамын иргэдийг шантаршгүй  
зоригоор чармайн дэмжсэнийг хэлэхийн  
газар юун!

Чинхай багш өөрийн хийсэн ажлаа  
бусдад мэдүүлье гэж ерөөс бодсонгүй.  
Гэвч түүний хийж байгаа хүмүүлэг ёсны  
ажлыг ертөнцийн олон газар орны засаг  
дарга нар сонсож мэдээд шайшаал  
хүртээжээ. Жишээлбэл: Хавайн

Хонололо хотын дарга 1993 оын 10 – р сарын 25 – ны өдрийг "Чинхай өдөр" гэж нийтлэв. 1994 оны 2 – р сарын 22 – ны өдөр, Иллино, Айува, Весконсин, Аркансас, Миссори, Минниесота зэрэг муж улсын дарга нараас " Чинхайн өдрийнг " хамтаар хүлээн зөвшөөрсөн байна. Үүнээс гадна бас Хонололод " Интернационалын эв найрамдлын шагнал" – ыг хүртэж, 1994 оны 2 – р сарын 22 – ны өдөр Чикаго хотын их цуглаан дээр " Дэлхийн оюун санааны удирдагч" гэсэн шагналыг хүртжээ. Шагнал олгох ёслол дээр ерөнхийлөгч Клинтон Буш. Ройта зэрэг дэлхийн олон орны засгийн ноёдын баярын цахилгаан утсыг хүлээн авчээ. Бас Америкийн хүндэт иргэн гэж нэрлэгджээ.

Орчмын жилүүдэд өөрийн дур сонирхолтой зүйл болох уран бүтээлээ

оролдсоор буй. Түүний уран бүтээлд уран зураг, хээтэй дэвүүр, чимэгтэй дэн, өрөөний чимэглэл, танхимын үзэмж, хувцасны загвар, шүлэг, дуу хөгжмийн зохиол зэрэг байна. Үүний ихэнхийг нигүүлсэнгүй үйлсэд мөнгө хуримтлуулахын төлөө зохион бүтээсэн юм.

Чинхай багш өөрөө төрөлх билэг нээгдсэн хүн биш гэж бидэнд ярьдаг. Багш уг нь эгэл ардтай адил амьдарч байсан болохоор бидний асуудал, хайр дурлал, өшөө хорсол, хүсэл шаардлага, сэжиг тааврыг сайн мэдэж байдаг. Эдүүгээ түүний амьралынх нь цорын ганц зорилт бол бидэнд тусалж, харанхуй мунхаг хугацааны гаслан зовлон ба гачигдал төөрөгдлөөс зайлуулж, хаан хурмастын номын утга агуулгыг төгс бүрэн ойлгуулах зүг удирдахад оршино.

Хэрэв та бэлтгэл ажлаа бүрэн гүйцэд хийчихсэн юм бол даруй таныг дагуулж гэрт чинь хүргэж өгөх болно.

Чинхай багш ном тайлахадаа шавь нарынхаа хэр хэмжээг Үндэслэж, нарийн дэлгэрэнгүй сэнхрүүлэн тайлбарладаг. Христийн шашинтан, Лалын шашинтан, бурхны шашинтан, бомбын шашинтанд цөм л ийм байдаг юм. Багш англи, франц, Герман, хятад, вьетнам зэрэг улсын хэлээр урсам сайхан ярьж чаддаг. Чинхай багшаас Арявалын номын цогцсыг сурч бясалгая гэж хүсэж байгаа хүмүүс Чинхай багшаас сэтгэлийн авишиг хүртэхээр ирэхийг баяртай угтан авна. Чинхай багш ном талайх ба сэтгэлийн авишиг хүртээхдээ мөнгө төгрөг гэж ерөөс авдаггүй билээ.

Хөвчин дэлхийд нисванис дүүрснээ  
Хэвэл цээжнээ гэгээн дүр бялхсан,  
Хэрвээ таныгаа ертөнцнөө залбаас  
Байдаг нисванис лав аяндаа арилна,  
Гэтэл даян дэлхий нисванис дүүрсэн  
тул  
Хэдий эрсэн ч танд олгох зохистой  
оронгүй.

Нар сар одон гаригийг би худалдан  
орхиод  
Гэгээн дүрийг чинь энэ орчлонд  
хоромхноо худалдан авах гэсэн  
Аа! Цаглашгүй гэрэлт бурхан  
Нигүүлсэнгүй гэрэл гялбаагаа энэ  
сүнсэнд хайрлана уу, Абида бурхан  
Ертөнцийн хүмүүс үдэш бүр  
дуулалдан бүжиглэж  
Ялимгүй бодисын дэн, эгэл